

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Намхайнямбуу	Дугаар	L304
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Эрдэнэбулган сум
Төрсөн газар	Эрдэнэбулган сум	Төрсөн он	1967
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Тусгалтын дуган	Сүм хийдийн дугаар	ХӨЭБ 056
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 19	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат

Хөвсгөл аймаг Эрдэнэбулган сумын Тусгалтын дуган

Мөнхбат: За манай судалгааны баг өнөөдөр 6 сарын 15-ны өдөр. Эрдэнэбулган сумын төвөөс зүүн хойш байх гуравдугаар баг буюу хуучин Зэрлэг багийн нутагт сумын төвөөс жар орчим км зайд орших Тусгалт хэмээх газар байсан энэ одоо буддын шашны нэгэн дуганы түүрийн тухай судалгааг авч дараах ярилцлагыг өрнүүлсэн юм аа. Тэгэхээр ярилцлага өгч байгаа хүн маань энэ Эрдэнэбулган сумын харъяат одоо багаасаа буддын шашны ном хийдийг гэрээр шавилан сурсан Намхайнямбуу хэмээх энэ дөч хэргэм насны лам хуваргатай уулзаж энэ ярилцлагыг хийсэн юм аа.Тэгэхээр одоо энэ Үүрийн голын цаад талд одоо энэ дуганы түүрх маань орших юм байна, тийм ээ.Тэгэхээр одоогоор Үүрийн гол маань бол гарах тийм ямар ч боломжгүй.Машин техникээр гатлах боломжгүй.Зөвхөн одоо жуулчдад зориулсан завь үйлчилж байдаг байна , тийм ээ. Тэгэхээр манай судалгааны баг бол энэ голыг гараад одоо тэр туурин дээр очих бол өнөөдөр бол боломж алга байна.Тэгэхээр хоёулаа эндээс одоо тэр туурийг баримжаалаад энэ ярилцлагаа хийе.Тэгэхээр энд бол нэг л дуган байсан гэж та хэлж байгаа,тийм ээ?

Намхайнямбуу: Тийм. Нэг л дуган байсан.Тэр Тусгалт гэдэг газар.

Мөнхбат: Байгаа ерөнхий газар бол Тусгалт?

Намхайнямбуу: Тусгалт.

Мөнхбат: Тэгэхээр Тусгалт хэмээх тэр газрын хойд талын уул нь одоо ямар уул байх вэ?

Намхайнямбуу: Хойд талын уул нь Баян-Өндөр.

Мөнхбат: За баруун хойно нь?

Намхайнямбуу: Баруун хойд талд нь Горхин.

Мөнхбат: Тэгээд басТарвагатай?

Намхайнямбуу: Тарвагатай. Горхин, Тарвагатай гэж хоёр газар.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: За голын наад талын энэ одоо захад байгаа тэр толгой?

Намхайнямбуу: Ишгэн толгой, урд талд. Урд талдаа, урд зүгтээ.

Мөнхбат: Туурийн зүүн талд байгаа, өөрөөр хэлбэл цаад талдаа гэсэн үг?

Намхайнямбуу: Цаад талдаа байгаа нь...

Мөнхбат: Ямар хясаа билээ, нэг хясаа л...?

Намхайнямбуу: Улаан хясаа.

Мөнхбат: Тэгэхээр энэ туурийн орчимд эртний болон одоо өнөөдрийн тахилгатай уул овоо үс мөрөн, ямар тахилгатай одоо ийм онгон савдаг газрууд байна вэ?

Намхайнямбуу: Ишгэн толгой, Баян-Өндөр гээд тахилгатай уулнууд байгаа. Дашлин овоо гэж нэг байгаа.

Мөнхбат: Тэгэхээр аль нь эндээс бөөгийн тахилгатай гэж та түрүүн байлаа?

Намхайнямбуу: Аа эндээс Ишгэн толгой гэдэг нь бөөгийн тахилгатай гэсэн.

Мөнхбат: Бөөгийн тахилагатай овоо...

Намхайнямбуу: Тийм.

Мөнхбат: Тэгэхээр таны одоо үзэж байгаагаар энэ ганц дуган байгын хурал бол явж байгаагүй байх, тийм ээ. Тэгэхээр ямар хуралтай байсан юм бол энэ?

Намхайнямбуу: Энэ улааны шашны хурал. Улааны шашны одоо...

Мөнхбат :Хугацааны хувьд одоо байнгын байсан юм уу, түр байсан юм уу?

Намхайнямбуу: Түр байсан юм болов уу гэж бодож байна.

Мөнхбат: Түр цагийн хурал?

Намхайнямбуу: Тийм, түр цагийн хурал байсан болов уу гэж бодож байна.

Мөнхбат :Тэгэхээр эндээс яг энэ туурин дээрээс одоо голынхоо тэрүүгээр яваад Даяндээрх ороход одоо 12-13 км байх болов уу гэж би таамаглаад байна?

Намхайнямбуу: Аа тэр хавьцаа байх байх.

Мөнхбат: Тэгэхээр магадгүй газарзүйн байрлалын хувьд ч аваад үзэхэд энэ Эг үүрийн сав нутгийн бүрхны шашны том төв байсан Даядээрхийн хүрээний ойролцоо ийм байсан болохоор энэ бол салбар нь байсан юм биш үү?

Намхайнямбуу: Тийм, салбар нь л байх. Нэг салбар нь л байсан байх.

Мөнхбат: Тэгээд тэр хүрээнээс лам нар гарч ирж одоо яадаг...?

Намхайнямбуу: Лам нар нь одоо энэ Зэрлэгт байсан, Зэрлэгт байрлаж байсан улсууд нь энэ наад хүрээндээ хурдаг байсан байх.

Мөнхбат: Наад хүрээндээ хурдаг тийм ээ?

Намхайнямбуу: Тийм, наад хүрээндээ хурлаа сайн хийдэг.Одоо энэ Зэрлэгээр нутаглаж байсан улсууд нь наанаа хурлаа хийдэг байсан байх.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: За танд баярлалаа. За ингээд үнэхээр Үүрийн гол бол одоо их хэмжээний устай.Тэгээд бид зорьж очсон болов чиг ингээд тавиад км яваад зорьж очсон боловч цаана голын тэртээ байх энэ дуган туурин дээр бол хүрч чадаагүй. Ийм учраас одоо энэ лам Намхайнямбуу гуайгаас энд одоо энэ туурийн голын наана энэ ярилцлагыг хийсэн юм аа.